



**МОНГОЛ УЛС**  
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**  
**ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 16 одор

Дугаар 157

Мандалговь

Г Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг  
сунгах талаар иргэдээс санал авч ажиллах  
ажлын хэсгийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “д”, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ**:

1. Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг сунгах талаар судлан иргэдээс санал авч ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	М.Анхбаяр	(Аймгийн Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд:	Б.Энхмандал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх, зүйн хэлтсийн мэргэжилтэн)
	C.Бат-Оргил	(Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч)
	Б.Золжаргал	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)
	Б.Бямбасүрэн	(Орон нутгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)

Г.Улааннаран	(Аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн)
--------------	--

Ц.Мөнх-Од	(Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Цаг уурын орчны технологийн хэлтсийн дарга)
-----------	---

Б.Уламбаяр	(“Дундговь-Ус” ОНӨҮГ-ын ашиглалтын инженер)
------------	---

О.Ганхуяг	(“Ган-Илч” ХХК-ийн гүйцэтгэх захирал)
-----------	---------------------------------------

Б.Батнаран	(“Тэвшийнговь” ХХК-ийн дулааны хэсгийн дарга)
------------	---

2. Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг сунгах талаар иргэдээс санал авч, холбогдох материал бүрдүүлэн Эрчим хүчний яам руу хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

